



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 74

Арвайхээр

Арвайхээр хотын Нийтийн тээвэр,
гэрэлтүүлэг, Орон нутгийн өмчит, аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газрын Удирдах
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 53 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 6.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг, Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Удирдах зөвлөлийн дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд: Э.Түмэнжаргал (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)
Т.Мөнхбаян (хотын Захирагчийн албаны архитектор)
Т.Чимэддорж (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)
Н.Дуламдорж (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

2. Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дагаж мөрдөх журам, жилийн ажлын төлөвлөлт, норм, нормативыг тогтоох эдийн засгийн бодит тооцоо судалгаа хийх, үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, төсвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр тогтмол хангаж ажиллахыг Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг, Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдах зөвлөл байгуулах тухай” 2021 оны 12 дугаар тогтоолыг 2021 оны 12 сарын 28-наас хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ц.ДОНЬДДОРЖ

